

**2017 ОНЫ 05 ДУГААР САРЫН 22-НЫ ӨДРИЙН  
НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР  
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН  
ЗАХИРАГЧИЙН ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР**

<b>№</b>	<b>Товч агуулга</b>	<b>Хэрэгжилт</b>
1	НИТХ-ын 10 дугаар чуулганаар хэлэлцэж баталсан Улаанбаатар хотын нутаг дэвсгэрийн хэмжээнд орчны бохирдлыг бууруулах талаар авах арга хэмжээний тусгай төлөвлөгөөг 05-09 дүгээр сарын хугацаанд хэрэгжүүлж ажиллах, цаг хугацаанд нь тайлан мэдээгээ НЗДТГ-ын Бодлого төлөвлөлтийн хэлтэст хүргүүлж ажиллах. /Нийт байгууллагуудад/	НХХААГ-ийн УБ хотын нутаг дэвсгэрийн хэмжээнд орчны бохирдлыг бууруулах талаар авах арга хэмжээний тусгай төлөвлөгөөний биелэлт 6 дугаар сараас эхлэн 9-р сар хүртэл батлагдсан. Тиймээс 2017 оны 5 дугаар сарын тайлан байхгүй болно.
2	Нийслэл дэх Төрийн аудитын газраас төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2016 оны сангийн нэгдсэн тайланд өгсөн аудитын зөвлөмж, аудитын дүгнэлтээр хязгаарлалттай дүгнэлт авсан төсвийн шууд захирагч, орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын удирдлагууд гаргасан зөрчлийг арилгах, цаашид гаргахгүй байх, Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/305 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллах. /НЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс, нутгийн захиргааны нийт байгууллагууд/	2016 оны сангийн нэгдсэн тайланд өгсөн аудитын зөвлөмж, аудитын дүгнэлтээр хязгаарлалттай дүгнэлт аваагүй болно.
3	Төсвийн тогтвортой орлогын эх үүсвэрийг бий болгох, батлагдсан төсвийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах, өр авлага үүсгэхгүй байх, сахилга батыг чангатгах, төсвийн зарлагын үр ашгийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах. /Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдлагууд/	Төсвийн тогтвортой орлогын эх үүсвэрийг бий болгох, батлагдсан төсвийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах, өр авлага үүсгэхгүй байх, сахилга батыг чангатгах, төсвийн зарлагын үр ашгийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллаж байна.

.....000.....